

Манмин Мэдээ

№ 45 2014 оны 4 сарын 6

Тэмдэг гайхамшиг, Эрх Мэдэлт хүч чадлаар

дүүрэн Гадаад орнуудад болсон нэгдсэн их цуглаануудын тухай GCN-(Жи Си Эн) телевизийн 'Дурсамж' хэмээх шинэ хөтөлбөр үзэгчдийн талархалыг хүлээн авч байна



ДОХ, төрөл бүрийн хүнд өвчтнүүд эдгэрч, мөн суумгай нь босож, дүлий нь сонсолтой болж, хэлгүй нэгэнийг ярьдаг болгосон Бурханы агуу гайхамшигт үйлс илрэн гарсан Угандагийн нэгдсэн их цуглааныг америкийн мэдээний сувгаар нэвтрүүлсэн юм. Энэ "Дурсамж" нэвтрүүлэг нь И Жей руг пасторын 2000 оны Угандад хийсэн нэгдсэн их цуглаан төдийгүй Пакистан, Кения, Филиппин, Орос, Герман, Перу, Конго, АНУ, Израйль, Эстонид хийсэн нэгдсэн их цуглаануудаар дамжуулан Есүс бол бүх хүн төрлөхтөний Аврагч юм гэж номлож түүнийгээ ч батлан харуулсан билээ (баруун доод талд: Ким Жин хүн ахлагч).

Ариун сайн мэдээ болон гайхамшигт эрх мэдэлт хүч чадлын үйлсийг дамжуулдаг GCN (Жи Си Эн) (www.gcntv.org) телевизийн 'Гадаад орнуудад хийсэн нэгдсэн их цуглаануудын дурсамж' гэсэн шинэ хөтөлбөр нь үзэгчдийн талархалыг хүлээж, магтаал сайшаалыг авч байгаа билээ. Энэхүү нэвтрүүлгийг явж эхэлсэн цагаас эхлэн Бурханы эрх мэдэлт хүч чадлыг маш гайхамшигтайгаар харуулсан И Жей руг пасторын гадаад орнуудад хийсэн нэгдсэн их цуглаануудын талаар үзэгчид үзээд эргэн дурсан санаж, сэтгэл нь их хөдөлж байгаа билээ.

1982 онд Манмин төв сүм байгуулагдаж, гурван том сорилтыг даван туулсаны дараа 2000 оноос дэлхий дахинаа сайн мэдээ тараах үйлчлэлээ хийж эхэлсэн юм. И Жей руг пасторын 2000 онд Угандад хийсэн Нэгдсэн их цуглаанд хамт явсан хүмүүс одоо ч тод санан дурсаж тэр үед болсон үйл явдлын гэрч нар юм.

И Жей руг пастор нь цуглаан эхлэхийн өмнө хэвлэл мэдээллийнхэнд хандан "Бүхнийг чадагч Бурхан ямар агуу хүч чадалтай, хүссэн бүхнээ

гайхамшигтайгаар хийдэг болохыг та нар харах болно" гэж хэлж байсан юм.

Яг түүний хэлсэнчлэн 2000 оны 7 сарын 5-6 нд явагдсан "Сүм сэргэлтийн нууц" сэдэвтэй Сүмийн удирдагчдын семинараар үй олон пасторууд өөрчлөгдөж бас эдгэрч байсан юм. 7 сарын 7-с эхлэн гурван өдрийн турш "Уганда нэгдсэн их цуглаан" нь Кампала Паркт болсон бөгөөд урлагийн багийнхан Ариун Сүнснээр бялхам байдал дотор Англиар болон төрөлх хэлээр нь магтан дуу дуулж, мөн Солонгосын үндэсний бүжиг нь тус цуглаанд оролцсон хүмүүсийн сэтгэлийг маш их хөдөлгөж халуун баяр хөөрийг авчирсан билээ.

Түүний дараа И Жей руг пастор тус цуглаанд "Бүтээгч Бурхан", "Яагаад Есүс Христ бидний цор ганц Аврагч вэ?", "Эдгээгч Бурхан" гэсэн сургаалуудыг номлож, түүний өвчин эдгээх залбирлаар эдгэрлийн агуу гайхамшигууд бий болсон юм. 23 жилийн турш явж чадахгүй байсан нэгэн эмэгтэй алхдаг болж, урт богино хөл тэгширч багтраа, саа өвчтэй, түлэгдсэн асар олон хүн эдгэрсэн.

Энэ төдийгүй дүлий хүн сонсолтой болж, хэлгүй нь ярьж, сохор нь хараа орж чөтгөрт эзэмдүүлсэн хүмүүс эрх чөлөөтэй болж, бүр ДОХ-р өвчилсөн хүмүүс эдгэрч, тоолж баршгүй олон хүн орон нутгийн шинж чанартай өвчнөөр өвчилж зовж, шаналж байсан өвчнөөсөө эдгэргээсэн юм.

Цуглааныг эсэргүүцэж байсан хүмүүс хүртэл Бурханы хүчээр хийгдэж байгаа төсөөлөхийн ч аргагүй энэ агуу гайхамшигт зүйлсийг хараад өөрийн эрхгүй нулимс унаган гэмшиж байсан юм. Энэ үйл явдлаар дамжуулан Угандагийн Нэгдсэн их цуглааныг ямар ч тохиолдолд саад хийх гэж оролдсон хүмүүс Бурхан эдгэрлийн агуу гайхамшигуудыг харуулж Манмин сүмээр дамжуулан Өөрийн зорилгоо гүйцэлдүүлж байгааг нотолж чадсан юм. Цуглааны эхний өдрөөс интернэт, U-TV болон C-TV-р шууд дамжуулж олон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлж байсан.

Түүнчлэн Америкийн мэдээний суваг болох CNN-р энэ гайхамшигт үйл явдлыг талаар мэдээлж байсан нь олон

хүмүүсийн анхаарлын төвд, мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хир их нөлөөлж байсныг харж болно. Түүний дараа GCN (Жи Си Эн) телевизийг үүсгэн байгуулж одоо 170 гаруй оронд цацаж байгаа билээ.

2013 оны 12 сарын 17нд 'Гадаад Орнуудад хийсэн нэгдсэн их цуглааны дурсамж' хөтөлбөр анх удаа нэвтрүүлэгдэж, энэ нэвтрүүлгээр Африкийн 54 оронд сайн мэдээ тараах үүд хаалгыг нээсэн Уганда Ариун Сайн Мэдээний тухай байсан юм. Дараа дараагийн дугаарт Ариун Сүнсний хүч чадлаар маш хатуу дэг жаягтай Исламын шашинтай Пакистан улсыг доргиосон Нэгдсэн Их цуглаан, гурван сая гаруй хүн оролцсон Хинди шашин ноёрхсон Энэтхэгт хийсэн цуглаан, Европын ард түмнийг сэрээсэн Германы нэгдсэн их цуглаан, Америкийн Нэгдсэн Улсын Мадисон Цэцэрлэгийн Талбайд зохион байгуулсан "Нью Йоркын нэгдсэн их цуглаан", Иудейн шашинтай Израйль улсад Есүс бол бидний Аврагч гэж тунхагласан "Израйлийн нэгдсэн их цуглаан"-уудын тухай нэвтрүүлэхээр бэлтгэж байна.

Төгс Хайр

“Хайр хэзээ ч дуусдаггүй. Харин эш үзүүлж байгаа бол, тэдгээр нь үгүй болно. Хэрэв олон янзын хэлүүд байгаа бол тэд болих болно. Хэрэв мэдлэг байгаа бол энэ ч үгүй болно... Харин эдүгээ итгэл, найдвар, хайр гурав үлддэг боловч хамгийн агуу нь хайр мөн” (1 Коринт 13:8-13).



И Жей руг Тэргүүн пастор

Хэрэв та Тэнгэрийн Орон орохдоо хүсэж байгаа зүйлүүдийнхээ нэгийг л авч орох боломжтой гэвэл юуг авч орох вэ?

Тэнгэрийн оронд, бидний алхаж гишгэдэг зам нь хүртэл шижир алтан зам юм. Мөн Бурхан Өөрийнхөө хайртай хүүхдүүдийнхээ зүрх сэтгэлийг ойлгож, энэ дэлхийн юугай ч харьцуулашгүй эрдэнэсийн чулуу, маш гоёмсог үзэсгэлэнтэй, үнэт гоёл чимэглэлээр болон алтаар хийгдсэн гайхамшигтай сайхан тэнгэрлэг орон байрыг танд бэлдсэн байгаа. Тиймээс та алт үнэт эрдэнэс авч явах нь ямар хэрэггүй үнэ цэнэгүй зүйл юм. Харин мөнхийн тэнгэрийн улсад ороод Бурхантай хайрыг өгч авалцахын тулд зайлшгүй хэрэгтэй зүйл байдаг бөгөөд энэ нь энэ дэлхийд амьдарч байхдаа бид өөрсдийн зүрх сэтгэлдээ бий болгосон сүнслэг хайр юм.

1. Тэнгэрийн оронд ч үүрд мөнх үнэ цэнэтэй байх хайр

1 Коринт 13:8-10-д “Хайр хэзээ ч дуусдаггүй. Харин эш үзүүлж байгаа бол, тэдгээр нь үгүй болно. Хэрэв олон янзын хэлүүд байгаа бол тэд болих болно. Хэрэв мэдлэг байгаа бол энэ ч үгүй болно. Учир нь бид хэсэгхэнийг мэддэг, хэсэгхэнийг эш үзүүлдэг. Харин төгс юм нь ирэх үед хэсэгхэн гэдэг нь үгүй болно.” гэсэн байдаг. Эш үзүүлж, харь хэлээр ярих, мэдлэг энэ бүгд Бурхан доторх сүнслэг зүйлүүд мөн ч гэсэн яагаад тэнгэрийн оронд байхгүй болох юм бол?

Тэнгэрийн орон бол сүнслэг орчин бүрдсэн төгс газар юм. Бид энэ дэлхийд хичнээн эш үзүүлдэг байлаа ч ирээдүйд тэнгэрийн хаанчлалд бүх зүйл бидний ойлголтоос шал өөр. Бид Тэнгэрийн оронд Бурханы болоод Эзний зүрх сэтгэлийг маш сайн ойлгох учраас тэнд эш үзүүлж ямар ч шаардлагагүй байх болно.

Хэлээр ярих ч мөн адил. Хэлийг нь мэдэхгүй хүнтэй ойлголцоход хэцүү байдаг бол Тэнгэрийн оронд ердөө л ганцхан хэлээр ярих учраас бусадтай ойлголцохгүй байх талаар санаа зоволтгүй. Тэнд зөвхөн сайхан сэтгэлээр л хэлж, ярих учраас ямар ч үл ойлголцол, атгаг хорон зүйл юу ч байхгүй.

Мэдлэгийн хувьд ч мөн л ялгаагүй. Энэ дэлхийд амьдарч байх хугацаандаа бид Бурханы Үгийг хичээнгүйлэн судалдаг. Бурханы хүсэл юу болох, яаж аврагдах талаар сурч мэддэг ч энэ нь бидний мэдэх ёстой мэдлэгийн жаахан хэсэг бөгөөд ердөө л Тэнгэрийн оронд орохыг зөвшөөрөх хэмжээний л мэдлэг юм.

Дээр дурдсанчлан эш үзүүлэх, хэлээр ярих, мэдлэг нь хэдийгээр Ариун Сүнснээс хамааралтай байдаг ч Тэнгэрийн оронд орохын тулд л энэ дэлхийд түр зуур хэрэглэгддэг юм. Тиймээс Тэнгэрийн орны талаар мөн үнэн үгийг судалж мэдэх нь чухал ч хамгийн чухал нь зүрх сэтгэлдээ хайрыг бий болгох нь л хамгийн чухал юм. Бид бүхэн зөвхөн өөрсдийн зүрх сэтгэлээ хичээнгүйлэн өөрчлөн шинэчилж, хайрыг олж авч чадвал тэнгэрийн хаанчлалд орж үүрд мөнх аз жаргалтай амьдрах болно.

2. Тэнгэрийн оронд хайрыг төгс мэдрэх болно

1 Коринт 13:11-г уншвал “Би хүүхэд байхдаа хүүхэд шиг ярьж, хүүхэд шиг боддог, сэтгэдэг байлаа. Би эрийн цээнд хүрээд хүүхэд насныхаа занг орхисон юм.” гэж байдаг

Тэнгэрийн оронд харанхуй юм уу, санаа зоволт, айдас, түгшүүр гэж ер байдаггүй. Тэнд зөвхөн сайхан сэтгэл, хайр л гэж байдаг учраас бид хайраа хамгийн дээд хэмжээнд бүрэн дүүрэн илэрхийлж чадна. Махан биеийн ертөнц, сүнслэг ертөнц хоёр нь хоорондоо асар их ялгаатай. Энэ дэлхий ертөнцөд ч итгэлийн хэмжээнийхээ дагуу хүн бүр өөр өөрөөр ярьж, ойлгож, боддог.

1 Иохан 2-р бүлэгт итгэлийн түвшин бүрийг тус бүрт нь ‘нялхасын’, ‘хүүхдүүдийн’, ‘залуусын’, ‘эцгүүдийн’ итгэл гэж ангилж харьцуулсан байдаг. Сүнслэг утгаараа хүүхдийн хэмжээний итгэлтэй байгаа хүмүүсийг ‘хүүхдүүдийн’ гэж олон тоонд хэлсэн байна. Мөн тэдний ойлголт мэдлэг нь хүртэл хүүхдүүд шиг байдаг тул сүнслэг гүн гүнзгий утгатай зүйлсийг ойлгодоггүй, Үгийг хэрэгжүүлэх өчүүхэн жаахан хүчтэй байдаг. Харин тэд сүнсээр өсөж залуусын, эцгүүдийн итгэлтэй болсон үед Бурханы хайрыг илүү өөрөөр мэдрч Үгийг хэрэгжүүлэх, харанхуйн хүчний эсрэг тэмцэж ялан дийлэх асар их хүч чадал, чадвартай болсон байх болно.

Хэдийгээр бид энэ дэлхий дээр байхдаа эцгүүдийн итгэлийг олж авсан ч махан биеийн орон зайд амьдарч байгаа учраас тэнгэрийн хаанчлалд орох хүртэл хүүхдүүд гэж хэлэгдэж болох юм. Энэ дэлхий дээр амьдарч байх хугацаандаа бид өөрсдийн хир чадлаараа л Тэнгэрийн орны итгэл найдвартай болж ямар гоё, үзэсгэлэнтэй болохыг мэдэж авсан ч Тэнгэрийн орны яруу алдар, үзэсгэлэнтэй байдлыг төгс ойлгоход үнэхээрийн хэцүү юм. Харин Тэнгэрийн орны тэрхүү сүнслэг урсгал дунд бид өөрсдөө ороод бүх зүйл ямар ер бусын гайхамшигтай, зах хязгааргүй өргөн уудам болохыг ойлгох болно.

Бидний энэ дэлхий дээр амьдарч байгаа нь Тэнгэрийн оронд үүрд мөнх амьдрахын тулд бэлтгэгдэж байгаа үе шат юм. Энэ дэлхийн амьдрал тэнгэрийн хаанчлалтай харьцуулвал маш хурдан яг л сүүдэр шиг хурдан яваад л өнгөрдөг. Их аз жаргалтай мөнх амьдрах мэт төсөөлж эхлэхэд л харамсалтай нь энэ амьдрал дуусч хэзээ ч үүрд мөнх биш байдаг.

Тиймээс 1 Коринт 13:12-г уншвал “Учир нь бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, харин дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ харин дараа нь би бүрэн мэдэх болно” гэсэн байдаг.

Бараг 2000 жилийн тэртээ элч Паул сүнслэг хайрын талаар энэ бүлгийг бичсэн. Тэр үед мөнгө, хүрэл, эсвэл ямар нэгэн металыг өнгөлөөд толь болгон хэрэглэдэг байсан учраас тусгал нь өнөөдрийнх шиг ийм тунгалаг тод байгаагүй. Бид тэнгэрийн оронд ороод л шууд үүрд мөнхийн Бурханы хаанчлал, төгс ертөнцийг мэдэрч, нэгбүрчлэн тодорхой харж, амь байгаа бүх юмс маш их ялгаатай болохыг харж мэдрэх болно. Мөн Бурханы яруу алдар, агуу сүр жавхлан, үгээр илэрхийлэшгүй үзэсгэлэнтэйг нь жинхэнэ бодитоор мэдрэх болно.

3. Итгэл, найдвар, хайр гурвын хамгийн агуу нь хайр юм

Бидний итгэлийн өсөлтөнд итгэл, найдвар бол маш их үнэ цэнэтэй нь юм. Бидэнд итгэл байсан цагт л аврагдаж, тэнгэрийн орон орж, Бурханы хүүхэд болж чадна. Хэрэв бидэнд итгэл байвал найдвар төрнө. Энэхүү итгэл, найдвараар л бид Тэнгэрийн оронд илүү сайн сайхан газар очиж, ариун болохыг хичээн зүтгэж, Бурханы хаанчлалын төлөө итгэмжтэйгээр ажиллаж чадна.

Итгэл, найдвар бол тэнгэрийн оронд очтол бидэнд байх ёстой гэж тайлбарласан байдаг. Тэгвэл яагаад 1 Коринт 13:13т “Эдүгээ итгэл, найдвар, хайр гурав үлддэг

боловч хамгийн агуу нь хайр мөн” гэж хэлсэн юм бол?

Нэгдүгээрт, итгэл, найдвар бол зөвхөн бид энэ дэлхийд амьдарч ‘хүн төрөлхтөнийг боловсруулж’ байх энэхэн хугацаанд л хэрэгтэй юм. Тэгвэл Тэнгэрийн оронд энэ гурваас зөвхөн сүнслэг хайр л үлддэг байна.

Хэрэв та жинхэнэ итгэлтэй бөгөөд Бурханыг хайрлавал цаг хугацаа өнгөрөх тусам тэнгэрийн орны хүсэл тэмүүлэл улам өссөөр Эзнийг илүү ихээр санагалзах болдог.

Ингэж тэнгэрийн орны хүсэл тэмүүлэлтэй болсон хүн нь энэ газар дээр хичнээн нарийн, хэцүү бэрх бартаатай замаар явж байсан ч “Хэцүү байна. Төвөгтэй юм” гэж гэдэггүй, ямар ч сорилт ирсэн ганхан хөдөлдөггүй. Харин эцсийн зорьсон газар болох Тэнгэрийн оронд очиход үл үзэгдэх зүйлд итгэн найдах тэр итгэл, мөн хүсэл тэмүүлэл ч хэрэггүй болж зөвхөн хайр л үлдэх болно. Ийм л учраас хамгийн агуу нь хайр гэж хэлээд байгаа юм шүү дээ.

Хоёрдугаарт, Итгэлээр тэнгэрийн орныг авах хүлээн авах ч хайр байхгүй л бол Тэнгэрийн орны хамгийн үзэсгэлэнтэй газар Шинэ Иерусалимд орж чадахгүй юм.

Бид итгэл, найдвараараа хир хэмжээнд үйлдэнэ тэр хирээрээ Тэнгэрийн оронд илүү сайн, сайхан газар орж чадна. Сүнслэг итгэл нь Бурханы Үгийн дагуу хир амьдарсан, гэм нүглээ хаясан, үзэсгэлэнтэй сайхан сэтгэлийг олж авсаныхаа хирээр өгөгддөг юм. Бидний итгэлийн хэмжээний дагуу Тэнгэрийн Оронд очих газар маань Диваажинд уу, 1-р шат, 2-р шат, 3-р шат Бурханы хаанчлалд, болон Шинэ Иерусалимд орох эсэх нь шийдэгдэх болно.

Шинэ Иерусалим бол итгэлээрээ төгс хайрыг зүрх сэтгэлдээ бий болгож чадсан Бурханы хүүхдүүдэд өгөгддөг газар юм. Бид Эзний зүрх сэтгэлийг дуурайж Шинэ Иерусалимд орохын тулд бид Эзний явсан замаар явах ёстой. Түүний зам бол хайр юм. Энэ хайрыг л бий болговол Ариун Сүнсний есөн үр жимс, 8н ерөөлийг боловсруулж, Эзний зүрх сэтгэлийг дуурайх болдог.

Тиймээс, бидэнд итгэл байвал Тэнгэрийн орон орж чадах бөгөөд найдвар байвал гэм нүглээ хаяж чадна. Итгэл найдвар байсан цагт гарцаагүй Тэнгэрийн орон орох боловч зөвхөн төгс хайрыг бий болгосон цагт Шинэ Иерусалим орж чадна. Тийм учраас хайр бол хамгийн агуу нь юм.

Хайрт итгэгч ахан дүүс минь, 1 Коринт 13-р бүлэгт гарсан сүнслэг хайрыг төгс бий болгож, Бурханыг баярлуулдаг ерөөлт итгэгчид болохыг Эзний нэрээр хүсэн гуйж байна.


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773
www.manmin.org
www.gcntv.org

Христэд ИТГЭГЧДИЙН ХУВЬД ИТГЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?



Асуулт: Би сүмд явж эхлээд нэг их удаагүй байгаа. “Эрдэнэсийн дундах эрдэнэс бол итгэл” ч гэдэг. Ер нь Христчин хүний хувьд итгэл гэж юу вэ? Энэ тухай мэдмээр байна.

Хариулт: Сүүлийн үед “Sunday Christian” буюу зөвхөн ням гариг буюу Эзэний өдөр л цуглаан руу “явдаг” хүмүүс маш олон болсон байдаг. Тэд бн өдрийн турш өөрсдийн дураар амьдарч байгаад ням гариг л цуглаанд ирдэг ба Христчин амьдралд маш өнгөцхөн хандаж, нэг их ач холбогдол өгдөггүй. Мөн олон янзийн сүм рүү зүгээр л сургаал номлол сонсох гэж очдог хүмүүс ч маш олон байдаг.

Энэ мэт хэдийгээр тэд Эзэний өдөр сүмд очиж байгаа ч тэд үл итгэгч хүмүүстэй адил өвчин зовлон, санхүүгийн болоод гэр бүлийн янз бүрийн асуудал нь шийдэгдэхгүй байсаар л байдаг. Яагаад тэр юм болоо? Яагаад гэвэл тэдэнд Бурханыг таньж мэдэх мөн Бурханы хүлээн зөвшөөрсөн жинхэнэ итгэл байхгүй учраас юм. Тиймд Христчин хүмүүсийн хувьд “жинхэнэ итгэл” гэж чухам юу болохыг харцгаая.

Итгэл: Бүтээгч Бурханд болоод Есүс Хрис бол бидний Аврагч гэдэгт итгэх нь



Ерей 11:3-г уншвал “Бурханы үгээр ертөнц бүтээгдсэн бөгөөд тийнхүү харагдах зүйлс нь үзэгдэх зүйлсээс бий болгогдоогүйг бид итгэлээр ойлгодог” гэсэн байдаг. Энд Бурхан Үгээрээ Тэнгэрийн орон болон энэ дэлхий ертөнц түүн дээр орших бүх зүйлсийг бүтээсэн гэдэгт итгэх итгэл юм.

Бурхан хүн төрөлхтөнийг болоод энэ дэлхий

ертөнцийг тэр чигээр нь бүгдийг нь бүтээсэн. Тэр Өөрийгөө бүтээлүүдээрээ дамжуулан батлан харуулж илчилсэн тухай Ром 1:20д бичсэн байдаг. Бид зүрх сэтгэлээ нээсэн цагт л Түүнийг бүтээгч Бурхан гэдгийг мэдэрч, энэ бодит ертөнцийг ойлгох болно. Мөн Түүний үг болсон Библиээр дамжуулан Бурхан бол амьд оршигч гэдгийг мэдэрч чадна. Зөвхөн итгээд ч зогсохгүй Бурханы хүмүүсээр дамжуулан гайхамшигт эрх мэдэлт хүч өчигдөр ч хийгдэж байсан, өнөөдөр ч хийгдэж байгааг хараад амьд оршигч Бурханд жинхэнээсээ итгэх болно.

Христчин хүн Есүс Христ бол бидний Аврагч Эзэн гэдэгт итгэж Ариун Сүнснийг бэлэг болгон хүлээн авах хэрэгтэй. Тэрээр Бурханы Хүү бөгөөд гэмт нүгэлтэй хүн төрөлхтөний өмнөөс модон загалмай дээр өлгөгдөн нас барснаар авралын замыг нээж

өгч, дахин амилан бидэнд мөнх амь ба Тэнгэрийн орны итгэл найдварыг өгсөн Есүс Христэд чин сэтгэлээсээ итгэх үед мөн урьдын үйлдсэн гэм нүглээ гэмшсэнээр Ариун Сүнснийг хүлээн авч, Бурханы хүүхэд болж, Тэнгэрийн оронд орох боломжтой болдог.

Түүнчлэн Христэд итгэгчдийн хувьд ‘Итгэл’ гэдэг бол Есүс Христийг Аврагч Эзэнээр хүлээн авч, Бүтээгч Бурханы хүүхэд болохыг хэлж байгаа юм. Хэрэв бид Библи дээр бичсэн Үгийн дагуу амьдарвал юу ч гуйсан түүнийгээ авч чадна. Тиймээс Эзэний адил сэтгэлийг олж авч чадсан Бурханы жинхэнэ хүүхэд болох гэж хичээн зүтгэдэг. Тэгээд эцэст нь 1 Петр 1:9д бичсэн шиг биднийг мөнхийн амьдрал руу аз жаргалтайгаар замчилж, Тэнгэрийн орны баяр хөөр, ивээлээр дүүргэх болно.

Итгэл: Бурханы хүүхэд болох эрхийг олж авч, үнэнээр өөрчлөгдөх



Маш олон хүн сүмд явж, Христэд итгэх итгэлийн амьдарлаар амьдардаг боловч эхнээсээ жинхэнэ

итгэлтэй байдаггүй. Мэдээж бид гэм нүглээ гэмшиж, Есүс Христийг хүлээн зөвшөөрөөд Ариун Сүнснийг хүлээн авбал Бурханы хүүхэд болох эрхийг олж авдаг. Мөн Бурхан гэж хэн болохыг, яагаад Есүс Христ бидний Аврагч, болсон болохыг Там, Тэнгэрийн орон бодитоор оршин байдаг гэдэгт итгэдэг бөгөөд энэ нь итгэлийн эхний шаг юм. Тэгээд бид Библид бичигдсэн Бурханы үгийн дагуу хий гэснийг нь хийж, бүү хий гэснийг нь хийхгүй байж, сахь гэснийг нь сахиж, хая гэснийг нь хаяж амьдрах хэрэгтэй. Ингэж Бурханы үгийн дагуу үйлдсэнээр л Бурханы хүлээн зөвшөөрөх

итгэлтэй болдог.

Олон жил итгэлийн амьдарлаар амьдарсан хүн Эзэний өдрийг ариунаар сахьдаггүй, аравны нэгээ төгс өргөдөггүй, урьдын л адил бусдыг үзэн яддаг, бусадтай хэрэлдэж маргалддаг бол түүнд жинхэнэ итгэл одоог хүртэл байхгүй байна гэсэн үг юм. Энэ үед өөрт байгаа гэмт чанар, хорон муу, атгаг бүхнээ олж мэдээд, чин сэтгэлээсээ залбирч өөрт байгаа хорон муугийн бүхий л хэлбэрийг хаях хэрэгтэй юм (1 Тесалоник 5:22). Библид бичигдсэн үнэнээр өөрчлөх хамгийн дөт зам бол эрдэнэсийн эрдэнэс болсон жинхэнэ итгэлийг авах юм.

Итгэл: Найддаг зүйлсийн баталгаа, харагдахгүй зүйлсийн бодит байдал



Өнөөдөр шинжлэх ухаан, анагаах ухаан хэдий их хөгжсөн ч хүний хүч чадал, хязгаараас даван гарсан маш олон асуудлууд, олон төрлийн шинэ өвчин

эмгэгүүд, аймшигт аюул, гай гамшиг, зовлон хүн төрөлхтөнд нүүрлэсээр л байна. Энэ бүх хүнд хэцүү асуудлуудыг зөвхөн Бурханы хүч чадлаар, жинхэнэ итгэлээр л шийдэгдэх боломжтой юм.

Библи энэ талаар Еврей 11:1-2т “Итгэл бол бидний найддаг зүйлсийн баталгаа, харагдахгүй зүйлсийн бодит байдал мөн. Учир нь урьдын хүмүүс түүгээр гэрчлэлийг хүлээн авсан аж” тайлбарласан байдаг. Хүний хүчээр огт хийж чадахгүй зүйлсийг Бүтээгч Бурханд итгэл итгэлээр тэр нь бодитоор биелэж, хүний нүдэнд харагдахгүй зүйлсийг итгэлийн нүдээр харж биелэвэл хичнээн их баяр хөөр, аз

жаргалыг мэдрэх вэ? Ингэж харж, мэдэрсэн хүмүүс ямар их ерөөлтэй, аз жаргалтай вэ! Бүхнийг чадагч Бурханы хүч чадлаар бодитоор огт боломжгүй зүйлс байсан ч хангалттай биелэгдэх боломжтой юм.

Ингэж Бурханы хүлээн зөвшөөрөх жинхэнэ итгэлтэй бол ямар ч хэцүү нөхцөл байдалд сэтгэлээр унаж, шантардаггүй юм. Тэд илүү их ивээл, ерөөлийг өгөх гэсэн Бурханы гүн гүнзгий хайрыг ойлгож, түүнд талархаж, Түүний хайрыг илүү их бодож, мэдэрдэг. Эцэст нь, итгэлээрээ гэм нүглээ хүлээн зөвшөөрч, гэмшсэнээр юу ч гуйсан түүнийгээ авч чаддаг байна.

Итгэл: Бурханыг хайрлах хайрын хэмжээ, чин сэтгэлээсээ Түүнд итгэх



Матай 7:21-г уншвал Намайг “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг

биелүүлдэг хүн орно гэсэн байдаг. Олон хүн “Эзэн минь, би Танд итгэдэг” гэж хэлдэг ч зөвхөн өөрийн эрх ашиг, ая тухтай байдлын төлөө л Христэд итгэх итгэлийн амьдарлаар амьдардаг. Тэд Бурхан тэднийг хир сайн мэддэгийг бас итгэдэг талаар ердөө ч боддоггүй. Харин жинхэнэ итгэл бол Бурханд чин сэтгэлээсээ итгэх итгэл, Түүнийг хайрлах таны хайрын хэмжээ юм.

Жинхэнэ итгэл найдвар бол ямар ч нөхцөл байдалд хэзээ ч гуйвдаггүй юм. Бид “би ийм учраас хүлээн зөвшөөрсөн харин үүнээс хэтрээд явчихвал би чадахгүй” гэж итгэл дотроо хязгаар тавьж болохгүй

бөгөөд энэ бодлуудаа даван туулснаар дуулгавартай байгаагаа харуулж чадна. Бурханыг чин зүрхнээсээ хайрлаж, Түүний чин сэтгэлийг ойлгож дуулгавартай байснаар Түүнээс гуйх итгэлтэй болно. Тиймээс ‘Итгэл’ бол Христчин амьдралын гол суурь, авралд хүрэх дөт зам, ивээл, ерөөл, хариултыг авахад зайлшгүй шаардлагатай зүйл юм.

Бид та бүхнийг Бурханд таалагдсан итгэлтэй болж, Бүтээгч Бурханы хүүхдүүд болох ерөөлийг авч, үүрд мөнх гэрэлтэх Тэнгэрийн Оронд нар мэт гэрэлтсэн илүү үзэсгэлэнтэй газарт орж чадна гэдэгт найдаж байна.

Миний ээжийн эмээ өвөө нь Эзэнд итгэдэг байсан. Жү Ги чул пастор миний ээжийн эмээ өвөөгийн хурмын ёслолыг үйлдэж, тослосон гэсэн. Ээж маань тэдний итгэлийн талаар надад ярьж, итгэлийн амьдралаар амьдрахыг үргэлж ятгадаг байлаа. Харин би эд хөрөнгө, нэр хүнд, жаргал цэнгэл хөөж, зүгээр сүм явдаг л нэгэн байсан билээ.

1997 онд гэрлэсэн жилээ Samsung компанид ажиллаж байх үед 'IMF-н эдийн засгийн хямрал'-ийн улмаас маш их бэрхшээлтэй тулгарч тэр их хяналт шалгалтын ид үед цомхотгол явагдаж, би тэсэж үлдэхийн тулд өглөө эрт үүр цайхаас авахуулаад шөнө болтол ажилладаг байлаа. Тэр үед итгэлийн амьдралыг бүр хаяж, зөвхөн энэ дэлхийн алдар нэр, ая тухтай амьдралын талаар боддог болсон байв.

Үүний дараа компаний маань байдал тогтвортой болж би сайн ажилчин гэж үнэлэгдэн, нэр хүндтэй болж байр сууриа эзэлсэн ч нэг л стрестэй байгаагаа сүнсээрээ мэдэрч байлаа.

Би ингэж амьдрах ёсгүйгээ мэдэрч, юу нь хамгийн үнэ цэнэтэй болохыг хайгаад ч олоогүй юм.

Энэ амьдралаас чөлөөлөгдөхийн тулд Канад руу явахаар шийдэж 2002 оны 5-р сард Калгори руу нүүж, сүмд явж эхэлсэн. Би бүх мөргөлүүдэд хамрагдахыг хичээж үүрийн залбиралд явж, сүмийн сайн дурын үйлчлэлд оролцож, хичээнгүйлэн Христчин амьдралаар амьдарч байв. Яг тэр үед би дэн буудлын үйл ажиллагааг их сонирхож байсан юм.

2004 онд Ким Чунхо сүмд үйлчлэгч (одоо Ким Пастор) И Жей руг пасторын Там ба Тэнгэрийн Орон I, II гэсэн номыг өгч Манмин Төв Сүмийн вэбсайтын талаар хэлсэн. И Жей руг пасторын амьдралын талаарх үнэтэй сургаалуудыг сонсоод сэтгэл их хөдөлж, ивээл авсан. Ийм итгэлтэйгээр аврал авч чадахгүй юм байна гэдгээ ойлгоод амьдралын зорилгоо өөрчлөх болсон. Мөн И Жей



“Миний бизнесийн өсөлтөнд нөлөөлсөн бялхам ивээл, ерөөлүүд”

И Хён гю ахлагч (Канад Калгори Манмин Сүм)

руг пастортой хувьчлан уулзах юмсан гэж чин сэтгэлээсээ хүсдэг байв.

2006 оны 7-р сард Ким Чун хо сүмд үйлчлэгчийн гэр бүлийнхэнтэй хамт Солонгост Манмин Төв сүмд ирсэн. Нэг сар солонгост байх хугацаандаа сүмээс маш их зүйлийг сурч, Бурханаар хайрлагдсан, Түүнд таалагдсан сүм болохыг харсан. Ялангуяа зуны хөтөлбөрт И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлаар миний нурууны булчингийн өвчин эдгэрсэн. Энэ бүгдээс сайн

хүртэл өргөл өргөсөн юм.

Үүний үр дүнд манай салон хэдийгээр нээгдэх үедээ маш доогуур үнэлгээтэй байсан ч 2012 онд 30 жилийн ойн баяраар Америк дахь удирдлагуудаас маш өндөр үнэлгээ авч хамгийн шилдэг борлуулалтын шагналыг авсан. Канадын статистик судалгаараар манай гэр бүлийн орлого топ 10 ордог. Энэ мэт И Жей руг пастортой уулзуулж, ивээл, ерөөлийг дүүрэн өгсөн Бурхандаа бүхий л алдар, магтаал, хүндэтгэлийг өргөж байна.

хоньчин хоньдынхоо төлөө амиа зориулан зүтгэх мэт И Жей руг пастор итгэгчдийнхээ төлөө өөрийгөө золиослон зүтгэж байгаа нь харагдсан билээ. Солонгост байх үед Ким сүмд үйлчлэгч Канадад Манмин Сүмийн сайн мэдээ тунхаглагчаар томилогдон Калгори Манмин Сүмийг нээсэн. Нью Йоркийн нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан И Жей руг пастор “Сүмийн санхүүд үйлчлэх шинэ бизнес эхлэх”-ийн төлөө 2006 оны 7 сарын сүүлээр ерөөлийн залбирал авсан.

Канадад буцаж ирэхэд Бурхан намайг агуу их ерөөлийн замаар удирдан замчилж, 2009 онд АНУ, Канадад 3000 ‘Great Clips’ гэдэг үсчний салоныг ажиллуулахаар болсон.

Ажлаа эхлүүлээд нилээд их бэрхшээлтэй тулгарсан ч энэ нь Бурханд итгэх төгс итгэл байхгүй байсан гэдгээ ухааран ойлгож гэмшээний дараа Бурхан боломжгүй зүйлийг хүртэл боломжтой болгож өгсөн.

Миний эхнэр Ким Ра на туслагч үсчний газар нээн ажиллаж байлаа.

Ингээд эцэст нь олонд танигдсан Канад үсчний газар болж, цаашид ажиллахад улам амар хялбар болсон. Би бүх цалин, орлогынхоо аравны нэгээ анх гаргасан шийдвэрээ марталгүйгээр төгс өргөж байсан бөгөөд одоог хүртэл өргөж, миний бизнесийн төлөө ерөөлийн залбирал хийж өгсөн И Жей руг пастортаа

“Ариун Сүнсний галыг авч босож алхдаг болсон”

Мирна Делмо (Филиппин дэхь Дабао Манмин Сүм)

20 жилийн турш нурууний хагалгааны улмаас зовж шаналж явсан билээ. Одоо бодоход хэзээнээс эхэлж манай гэрийн хаалганд хавчуулдаг байсныг мэдэхгүй ч тэр хавчуулсан Манмин Мэдээ сонинг уншиж их ивээл авдаг байсан.

Тэгээд тэгээд сонинг уншаар ивээл авч Дабао Манмин Сүмд бүртгүүлсэн Ким Үн жа пасторын сүмийн итгэгч болсон юм. 2013 оны эхээр хөл маань мэдээ алдаж ямар ч хүчгүй сул болоод өөрөө явж чадахаа больсон. Яг л энэ үед И Хи сон пасторыг урьсан “Эдгэрэл ивээлийн цуглаан” гар

алчуурын цуглаан (Үйлс 19:11-12) болох талаар сонссон юм.

2013 оны 12 сарын бнд И Хи сон пастор нь Эдгэрэл ивээлийн цуглаан –д сургаал айлдаж, И Жей руг пасторын залбирч өгсөн гар алчуураар өвчтэй хүмүүсийн төлөө залбирал хийж өгсөний дараа үйлчлэлийн багийн хүмүүсийн нэг нь намайг сууж байхад ирээд босох хэрэгтэй гэж хэлэхэд би босч чадаагүй. Гэсэн ч хамгийн гайхамшигтай нь би үүний дараа сүмд босоод зогсож байсан юм.

Би яг яаж явж чадсанаа сайн санахгүй ч агаарт хөвөөд байгаа юм шиг мэдрэмж надад төрж байсан. Тэгээд И Хи сон пастор сургаал зааж, магтаалыг удирдаж, залбирсан. Би сүмийнхээ итгэгч нартайгаа хамт бүр бүх биеэрээ бүжиглэж магтаалыг өргөж байлаа. Энэ бол надад урьд өмнө хэзээ тохиолдож байгаагүй гайхамшиг юм.

Би Ариун Сүнсний галыг авч гэртээ буцаж ирсэн ч сул дорой бие минь халуун оргиж, унтаж чадаагүй. Маргааш өглөө нь гайхамшиг болж, ямар ч тусламжгүйгээр явж чаддаг болсон байлаа. Халлелүяа!



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин